



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/71

Бат-Өлзий сум

Шууд худалдан авах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.9 дэх заалт, Засгийн газрын “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 25 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум дундын Ойн ангид Хуш модны нөөц тогтооход шаардлагатай техник хэрэгслээр хангах дрон, зургийн аппарат, байршил тогтоогч худалдан авах ажлыг ажлын хэсгийн 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар хурлын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн “Их говийн мандах булаг” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай худалдан авах гэрээ байгуулж гүйцэтгүүлсүгэй.

2. “Их говийн мандах булаг” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллахыг сум дундын Ойн ангийн дарга (Д.Очирхуяг)-д даалгасугай.

3. Хуш модны нөөц тогтооход шаардлагатай техник хэрэгслээр хангах дрон, зургийн аппарат, байршил тогтоогч худалдан авах зардалд шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН